



АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас: 70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Ахлах аудитор М.Айнур
Ахлах аудитор Х.Манаргүл
Аудитор Д.Назгүл
Аудитор Б.Үүрийнтуяа
Аудитор Ж.Назгүл
Аудитор Х.Еркебулан

Утас: 94159291

Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.audit.mn

2018 оны 4 дүгээр сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Товчилсон үгийн жагсаалт

АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААН	Аж ахуйн нэгж
АТӨЯХ	Авто тээврийн өөрөө явагч хэрэгсэл
БХС	Байгаль хамгаалах сан
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНС	Засаг даргын нөөцийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОН	Орон нутаг
ОНӨААТҮГ	ОН-ийн өмчит аж ахуйн төсөвт үйлдвэрийн газар
ОНӨҮГ	ОН-ийн өмчит үйлдвэрийн газар
ОНХО	ОН-ийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийг хөгжүүлэх сан
СНТ	Санхүүгийн нэгтгэсэн тайлан
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /БӨА-2018/01/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 4 дугаар сарын 01-нээс 4 дугаар сарын 20-ны хооронд хийхээр төлөвлөж, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур ахлагчтай аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 1-01/363 дугаар албан бичгээр 4 дүгээр сарын 01-ний өдөр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 4 дугаар сарын 01-нээс 4 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 4 дугаар сарын 25-нд Аймгийн Засаг даргад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Аймгийн Засаг дарга нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжүүлэх төрийн бодлогыг аймгийнхаа онцлогт тохируулан боловсруулж, үр дүнтэй өндөр чадавхтай, зөв зохион байгуулалттай, хариуцлагатай удирдлагын тогтолцоог бүрдүүлж, байгаль орчин, бизнест ээлтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргаж, ард иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах, аж амьдралыг дээшлүүлнэ” гэж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д “аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч байна”, 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах эрхийг хэрэгжүүлнэ”, 14 дүгээр зүйлийн 3-т “ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн төлөөлөгчийн хурал, Засгийн газар, УИХ-ын өмнө хариуцана” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.17-д заасны дагуу Аймгийн Засаг дарга нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Аймгийн Засаг даргын 2017 оны төсвийг аймгийн улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 40-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг Засгийн газрын Е-тайлан цахим системд боловсруулан, төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан байна.

Тав. Дотоод хяналт:

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ыг баримтлан, Төсвийн тухай хуулийн 54.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузль

суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Засгийн газрын Е-тайлан цахим системд харьяа байгууллагуудын шивж оруулсан санхүүгийн тайланг системээс татаж, давхардсан гүйлгээг арилган, нэгтгэж гаргасан байна.

Байгууллагын төрлөөрх тайлангийн нэгтгэлийг салбараар нь ангилж, гаргаж ирүүлсэн. Санхүү, төрийн сангийн хэлтсийн зүгээс санхүүгийн тайлантай холбоотой тодруулга, нэмэлт судалгаануудыг бэлтгэж ирүүлсэн болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд харьяа төсөвт байгууллага, төрийн сан, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, төсөл, сангуудын санхүүгийн тайланг бүрэн хамруулжээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй:

А. Үндсэн тайлан:	Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан	В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан	СНТ-ийн тэмдэглэл, тодруулга
ТЕЗ-ийн санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан	
ТЕЗ-ийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан	
ТЕЗ-ийн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан	Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаагүй илэрхийлсэн эсэхийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Өлгий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн тухай хуулийн 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитыг хэрэгжүүлэх” гэж заасныг баримтлан 2014 оноос эхлэн Засаг даргын дэргэд дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн хяналт, аудитын албыг байгуулан ажиллуулж ирсэн байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2017 онд 88 нэгжид шалгалт хийхээр төлөвлөснөөс 74 төсөвт байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж, төлөвлөгөөт шалгалтын биелэлт 84,1 хувьтай байна. Харин төлөвлөгөөт бус шалгалтаар 23 төсвийн байгууллагыг шалгасан байна.

2017 онд санхүүгийн хяналтыг үр нөлөөтэй болгох, урьд хэвшил болсон ажлын арга барилыг өөрчлөн, мэдлэг боловсрол, ажлын туршлагад тудгуурлан тухайн байгууллагаас гарсан зөрчил, дутагдлыг таслан зогсоож арилгуулах, хууль зүйн, мэргэжлийн зөвлөгөө өгч, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд түлхүү анхаарч, байгууллагын үйл ажиллагааг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан явуулж, санхүүгийн сахилга батыг сайжруулан, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх, өр, авлага гаргахгүй байх, төрийн болон төсвийн хөрөнгө мөнгийг зориулалтын дагуу, хуулийн хүрээнд зарцуулсан эсэхэд шалгалтыг чиглүүлэн ажиллажээ.

2017 онд хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтын дүнг сумын удирдлага, шалгалт хийгдсэн байгууллагын дарга, эрхлэгч, захирал, санхүү бүртгэлийн ажилтан, бусад холбогдох хүмүүст танилцуулан, шалгалтаар гарсан зөрчил, дутагдлыг таслан зогсоох, хууль тогтоомжийг мөрдөн ажиллан, дахин давтаж гаргахгүй байхад чиглэгдсэн арга хэмжээ авч ажиллахыг зөвлөмж чиглэл болгосон байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар шилэн дансын хэрэгжилтийг хангуулах ажилтан болон улсын байцаагч нар хяналт тавьж ажилласан байна.

Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналтын алба үйл ажиллагааны зорилтоо “Төсвийн тухай хууль, төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүйн актыг сумдын санхүүгийн алба, төсөвт байгууллагууд хэрхэн хэрэгжүүлж буй байдалд дотоод хяналтыг хэрэгжүүлж, гарч болзошгүй эрсдэлийг үнэлэх, үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж өгч, дотоод хяналтын нэгдсэн дүнг танилцуулахад оршино” гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 36.6 дахь хэсэгт заасны даруу харьяа төрийн сангуудын үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ аймгийн Засаг даргын баталсан төлөвлөгөө, төрийн сангийн хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу мемориалын баримт, төсөвт байгууллагын гарын үсэгний баталгааны бүрдэл, Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд хийгдсэн гүйлгээ, санхүүжилтийн хуваарилалт, төсвийн гүйэтгэлийн мэдээг нэгтгэн гаргасан байдал зэргийг хамруулжээ.

Тайлант онд Төрийн сангийн хэлтсийн даргын баталсан дотоод хяналт хийх ажлын удирдамжийн дагуу Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Улаанхус, Дэлүүн, Сагсай, Цэнгэл, Ногоонуур, Өлгий сум, Цагааннуур тосгоны төрийн сангийн үйл ажиллагаанд Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу үйл ажиллагаагаа явуулж буй эсэхэд шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилган ажиллах талаар зөвлөмж өгсөн байна.

Тайлант онд хийгдсэн хяналт шалгалтаар Булган, Бугат, Цэнгэл, Сагсай, Ногоонуур, Баяннуур, Улаанхус сумдын төрийн сангийн нэгжийн төсвийн байгууллагын зарлагын гүйлгээнд тавих хяналт сул, бусад төрийн сангуудын үйл ажиллагааг хэвийн түвшинд явагдаж байна гэж үзсэн байна.

Зургаа. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу улсын төсвийн санхүүгийн дэмжлэг, аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР ТОДРУУЛГА

Долоо. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын жижиг мөнгөн сан, харилцах дансны үлдэгдэл, ОНӨҮГазар, төсөл сангийн харилцах дансдын үлдэгдэл
- Кассад байгаа бэлэн мөнгө

ОН-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2041,0 сая төгрөг байснаас 45,6 хувиар нэмэгдэж, 2971,8 сая төгрөгөөр тайлагнагдсан бөгөөд үүний 73,2 хувь буюу 2174,7 сая төгрөг нь төрийн сангийн харилцах данс дахь мөнгө байна.

ОН-ийн төсвийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийг бүтцийг байгууллагын төрлөөр харуулбал:

(сая/ төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	19,0	32,8	32,7		
Төгрөг/ЖМС	19,0	32,8	32,7		
Банкинд байгаа бэлэн мөнгө	2022,0	2939,1		764,3	2174,9
Төгрөг	2022,0	2939,1	32,7	764,3	2174,9
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	2041,0	2971,9	32,8	764,3	2174,9
Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:					
Төрийн сан	1010,3	1558,0			1558,0
Төсөвт байгууллагууд	591,0	555,8	16,5	65,1	474,2
ОН-ын өмчит үйлдвэрийн газар	427,8	715,3	16,2	699,1	
Төсөл, сангууд	11,9	142,8		0,1	142,7

Оны эхний үлдэгдэлтэй харьцуулбал, нийт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 931,0 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор, төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 547,7 сая төгрөгөөр, ОНӨҮГ-ын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 287,5 сая төгрөгөөр, төсөл сангуудын үлдэгдэл 130,9 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Төсөвт байгууллагуудын мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 35,2 сая төгрөгөөр буурсан байна.

Төрийн сан дахь 2174,7 сая төгрөгийг задалж авч үзье эл аймгийн төсвийн ерөнхий орлогын данс 500,1 сая төгрөгийн, сумдын төсвийн ерөнхий орлогын данс 1057,5 сая төгрөгийн, Сум хөгжүүлэх сан 303,1 сая төгрөгийн, аймгийн ОНХСан 1,2 сая төгрөгийн, сумын ОНХСан 74,8 сая төгрөгийн, Замын сан 25,9 сая төгрөгийн, Эх хүүхдийн дэмжих сан 0,2 сая төгрөгийн, Мал хамгаалах сан 136,6 сая төгрөгийн, ОН-ийн хөрөнгө оруулалтын данс 20,5 сая төгрөгийн, бусад сангуудын данс 40,0 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба нэмэлт санхүүжилтээс 15,0 сая төгрөг татан төвлөрүүлсэн үлдэгдэлтэй байна.

Банкин дахь ОН-ийн харилцах дансны талаар

Арилжааны банкинд нийт 764,3 сая төгрөг байршиж байгаагийн 38,7 сая төгрөг нь төсөвт байгууллагуудын, 30,1 сая төгрөг нь бусад байгууллага, төсөл сангуудын, 695,5 сая төгрөг нь ОНӨААН-ийн харилцах дансны үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгөтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна.Үүнд:

- “СУАТ” ХХК нь санхүүгийн тайланд тусгасан мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг арилжааны банкуудаас ирүүлсэн харилцах дансны үлдэгдлийн баталгаатай тулгаж шалгахад банкин дахь мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлийг 22802,37 төгрөгөөр зөрүүтэй тайлагнажээ.

Найм. Авлагын бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлага оны эцэст 4910,5 сая төгрөгт хүрч оны эхнээс 244,8 сая төгрөгөөр буурсан байна.

Нийт авлагын үлдэгдлийг бүтцээр нь харуулбал:

(сая төгрөгөөр)

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
Ажиллагчидтай холбогдсон авлага	21.9	26.2	4.3	119.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	92.9	98.2	5.3	105.7
Татаас, санхүүжилтийн авлага	197	32.5	-164.5	16.5
Зээлийн хүүгийн авлага	19.9	23.6	3.7	118.6
Дансны авлага /ТӨҮГ/		1.1	1.1	
Татвар, НДШ /ТӨҮГ/		0.2	0.2	
Байгууллагаас авах авлага	468.1	494.1	26	105.6
Хувь хүмүүсээс авах авлага	52.7	52.9	0.2	100.4
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	250.4	250.4	0	100.0
Хувь хүмүүст СХСангаас олгосон зээл	4094.9	3931.4	-163.5	96.0
НИЙТ ДҮН	5,197.8	4910.5	-287.3	94.5

Авлагыг бүтцээр нь авч үзвэл: ажиллагсадтай холбоотой авлага, төлбөртэй үйлчилгээний авлага, зээлийн хүүгийн авлага, дансын авлага, хувь хүмүүсээс авах авлага, татвар, НДШ-ийн авлага, байгууллагаас авах авлага 0,2-26,0 сая төгрөгөөр нэмэгдэж, татаас санхүүжилтийн авлага, хувь хүмүүст СХСангаас олгосон зээлийн авлага 163,5-164,5 сая төгрөгөөр буурчээ.

Сумдын ОНХСангийн татаас санхүүжилтийн авлага, СХСангийн зээлийн авлага барагдсан дүнгээр буурсан байна.

Авлагын үлдэгдлийг салбараар ангилж харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

(сая төгрөгөөр)

Салбар, нэгжийн нэр	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	зөрүү	хувиар
Төрийн сан	250.4	256.8	6.4	102.6
Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газар	512.6	588.0	75.4	114.7
Төсөвт байгууллага	4434.8	4065.8	-369.0	91.7
Төсөл сангууд	0		0	
Нийт дүн	5197.8	4910.6	-287.2	94.5

Төрийн сангийн авлага 6,4 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрын авлага 75,4 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөвт байгууллагуудын авлага 369,0 сая төгрөгөөр буурсан байна.

Төсөвт байгууллагуудын авлагатай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн.Үүнд:

- Баяннуур сумын Хүүхдийн цэцэрлэг нь Шүүхийн шийдвэрээр олгосон 4,0 сая төгрөгийг авлагаар бүртгэж, он дамжсан 3,4 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Өлгий сумын Хүүхдийн 13 дугаар цэцэрлэг санхүүгийн тайланд 0,7 сая төгрөгийн авлагыг тусгаж харуулаагүй, Өлгий сумын “Эрдэм” хүүхдийн цэцэрлэг санхүүгийн тайланд 0,4 сая төгрөгийн авлагыг илүү харуулсан, Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургууль ХХОАТ-ын 1,1 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан, Сум дундын ойн анги авлагыг 1,5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, Бугат сумын Хүүхдийн цэцэрлэгийн жилийн эцэст бараа материалын тооллогоор илэрсэн дутагдлыг санхүүгийн байдлын тайланд үлдэгдлээр тайлагнаж, материалын үлдэгдлийг бодитой илэрхийлээгүй, тооллогоор илэрсэн дутагдлыг шийдвэрлэж, авлагаар харуулаагүй байна.
- Аймгийн ИТХ суутгасан 0,4 сая төгрөгийн ХХОАТ-ыг дутуу төлж, авлагаар тусгаж харуулаагүй, Бугат сумын бүрэн дунд сургууль суутгаж аваагүй орхигдуулсан 0,7 сая төгрөгийн, Бугат сумын ЗДТГ-д 4,8 сая төгрөгийн авлагыг нөхөн төлүүлэхээр тус тус акт тогтоосон.

Орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжийн урьдчилж гарсан зардал оны эцэст 36,6 сая төгрөг болж, оны эхнээс 1,0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
УРЬДЧИЛГАА	35,6	36,6	1.0	102,8
Урьдчилж гарсан зардал	35,6	36,6	1.0	102,8

“Суат” ХХК-нд бүртгэлтэй бөгөөд өнгөрсөн онд санхүүжилт нь орж ирээгүй төслийн хөрөнгөөр хийсэн ажлын өртгийг санхүүгийн тайланд урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн нь тайлант онд 1,0 сая төгрөгөөр буурсан байна.

Ес.Бараа материалын бүртгэл, тайлагнал

Бараа материал оны эхэнд 3,240.3 сая төгрөгийн үлдэгдэл ба оны эцэст 3,510,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарч, оны эхнээс 269,8 сая төгрөгөөр өссөн байна. *(сая.төгрөгөөр)*

Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Хувиар
БАРАА МАТЕРИАЛ				
Түүхий эд материал	140.1	77.0	-63.1	55.0
Тусгай зориулалтын материал	63.2	211,7	148.5	334.9
Эм боох материал	76.9	77	0.1	100.1
Дуусаагүй үйлдвэрлэл	19.2	42.8	23.6	222.9
Бэлэн бүтээгдэхүүн	62.8	53.5	-9.3	85.2
Хангамжийн материал	2988.6	3045.6	57	101.9
Мал амьтад	294.3	278.7	-15.6	94.7
Нөөцийн бараа	7.4		-7.4	0.0
НИЙТ ДҮН	3512.4	3632,4	120.0	103.4

Тусгай зориулалтын материал 148,5 сая төгрөгөөр, эм боох материал 0,1 сая төгрөгөөр, дуусаагүй үйлдвэрлэл 23,6 сая төгрөгөөр, хангамжийн материал 57,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, Түүхий эд материал 63,1 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүн 9,3 сая төгрөгөөр, мал амьтад 15,6 сая төгрөгөөр нөөций бараа 7,4 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Нийт бараа материалын үлдэгдэлд түүхий эд материал 5,8 хувийг, дусаагүй үйлдвэрлэл 1,2 хувийг, бэлэн бүтээгдэхүүн 1,5 хувийг, хангамжийн материал 83,8 хувийг, мал амьтад 7,7 хувийг тус тус эзлэж байна.

Оны эцсийн бараа материалын үлдэгдлийн 3409,1 сая төгрөг буюу 93,8 хувь нь төсвийн байгууллагын, 223,3 сая төгрөг буюу 6,2 хувь нь орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үлдэгдэл байна.Төсөл сангууд бараа материалын үлдэгдэлгүй байна.

Аудитаар бараа материалын бүртгэлтэй холбоотой дараах алдаа зөрчил илэрлээ.

- Улаанхус сумын ЗДТГ сумын орлогын давсан хэсгээс зарцуулсан 9,5 сая төгрөгийн түлш, тээвэр шатахууны зардлыг орлого авч, данс бүртгэлд тусгаагүй.
- Алтай сумын бүрэн дунд сургууль 72,8 сая төгрөгийн бараа материалыг буруу ангилж бүртгэсэн.
- Бугат сумын Хүүхдийн цэцэрлэг тооллогоор илэрсэн 0,6 сая төгрөгийн дутагдсан материалын зардалд бичсэнийг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Булган сумын Хүүхдийн цэцэрлэгийн нярав 2017 онд бараа материалын тайланг зохих журмаар гараагүй, түүнд нягтлан бодогчийн зүгээс хяналт тавиагүй.
- Баяннуур сумын бүрэн дунд сургууль жилийн эцэст тооллого хийсэн боловч, тооцоог бодож, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй.

- Баяннуур сумын ЭМТөв эм нийлүүлсэн компаниудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, жилийн эцсийн тооллогын материалыг ирүүлээгүй.
- Буянт сумын ЗДТГ-ын нярав 1-9 сарын 17,7 сая төгрөгийн аж ахуйн материалын тайланг гаргаж ирүүлээгүй.
- Суат ХХК нь 60,4 сая төгрөгийн бараа материалыг орлогод авалгүй шууд зардлаар бүртгэсэн.

Арав. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үндсэн хөрөнгө 2017 оны эцэст 154,422.8 сая төгрөг байсан бол тайлант онд 8017,3 сая төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 162,440.1 сая төгрөгөөр тайлагнагдсан байна.

Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

(сая.төг)

Ангилал	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү дүн
Барилга байгууламж	106,423.80	111,169.40	4,745.60
Тээврийн хэрэгсэл	4,536.90	4,534.70	-2.20
Машин тоног төхөөрөмж	26,428.90	26,463.10	34.20
Тавилга эд хогшил	5,889.70	5,767.50	-122.20
Дуусаагүй барилга	3,736.90	143.2	-3,593.70
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,554.40	1,570.20	15.80
Зам, гүүрийн байгууламж	2,298.10	6,025.40	3,727.30
Бусад үндсэн хөрөнгө	10,226.40	10,605.50	379.10
Ном	1,231.20	1,239.70	8.50
Биет бус хөрөнгө	113,8	115,3	1.50
Дүн	162,440.10	167,634.00	5,193.90

Нийт үндсэн хөрөнгийн 66,4 хувийг барилга байгууламж, 2.7 хувийг тээврийн хэрэгсэл, 15,8 хувийг машин тоног төхөөрөмж, 3.4 хувийг тавилга, эд хогшил, 0,1 хувийг дуусаагүй барилга байгууламж, 0,9 хувийг түүх соёлын дурсгалт зүйлс, 3,6 хувийг зам гүүрийн барилга байгууламж, 6,3 хувийг бусад үндсэн хөрөнгө, 0,7 хувийг ном, 0.1 хувийг биет бус хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд үндсэн хөрөнгө 12964,2 сая төгрөгөөр нэмэгдснээс 336,7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч, 12627,5 сая төгрөгийн үүндсэн хөрөнгийг хандивын хөрөнгөөр болон бусад эх үүсвэрээс шилжүүлэн авч, 7770,5 сая төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 167633,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Тайлант онд барилга байгууламж 4745,6 сая төгрөгөөр, машин тоног төхөөрөмж 34,9 сая төгрөгөөр, зам гүүрийн барилга байгууламж 3727,3 сая төгрөгөөр, бусад үндсэн хөрөнгө 379,1 сая төгрөгөөр, ном 8,5 сая төгрөгөөр, биет бус хөрөнгө 1,5 сая төгрөгөөр нэмэгдэж, тээврийн хэрэгсэл 2,2 сая төгрөгөөр, тавилга эд хогшил 122,2 сая төгрөгөөр, дуусаагүй барилга 3593,7 сая төгрөгөөр, түүх соёлын дурсгалт зүйлс 6,8 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгө дансны талаар

ОНӨҮГ-ын үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулбал дараах байдалтай байна:

/сая.төгрөгөөр/

№	ОНӨААН байгууллагууд	Үндсэн хөрөнгө		Өсөлт, бууралт
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	"Жана өлке" ОНӨТҮГ	3,094.70	2984,8	(109,9)
2	"Суат" ХХК	3,848.90	3791,5	(57,4)
3	ЦШСГ	8,668.70	7944,8	(723,9)
4	"Хала өркени" ОНӨТҮГ	2,311.30	2152,8	(158,5)
5	"Сансар" эмнэлэг	153.10	195,8	427,0
	Бүгд дүн	18076,7	17069,8	(1006,9)

Өмнөх онтой харьцуулж үзвэл "Хала өркени" ОНӨОҮГазрын үндсэн хөрөнгө 158,5 сая төгрөгөөр, "Жана өлке" ОНӨТҮГазрын үндсэн хөрөнгө 109,9 сая төгрөгөөр, ЦШСГ-ын үндсэн хөрөнгө 723,9 сая төгрөгөөр, "Суат" ХХК-ны үндсэн хөрөнгө 57,4 сая төгрөгөөр тус тус буурч "Сансар" эмнэлгийн үндсэн хөрөнгө 427,0 сая төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

- Толбо сумын ЗДТГ нь санхүүгийн тайланд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэж дууссан 102,2 сая төгрөгийн барилга байгууламжийг дуусаагүй үйлдвэрлэл данснаас шилжүүлж бүртгээгүй байсныг залруулахаар зөвлөмж өгсөн.

Арван нэг.Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 5,634.1 сая төгрөг байснаас тайланд онд 562,5 сая төгрөгөөр өсч, оны эцэст 6,210.6 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт өр, төлбөрийн үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Богино хугацаат өр төлбөр	2,446.30	2,724.90	278.60
Богино хугацаат зээлийн өглөг	5,2	-	-5.20
Өглөг	2,175.00	2,620.50	445.50
Урьдчилж орсон орлого	266.1	104.4	-161.70
Урт хугацаат өр төлбөр	3,147.60	3,485.70	338.10
Урт хугацаат зээл	3,147.60	3,485.70	338.10
Нийт өр төлбөрийн дүн	5,593.90	6,210.60	616.70

Өр төлбөрийн эцсийн үлдэгдлийн 43,9 хувийг богино хугацаат өр төлбөр, 56,1 хувийг урт хугацаат өр төлбөр тус тус эзэлж байна. Богино хугацаат өр нийт дүнгээр 278,6 сая төгрөгөөр, урт хугацаат өр 338,1 сая төгрөгөөр өссөн байна.

Богино хугацаат өглөгийн салбараа нь задалж харуулбал:

Салбар, нэгжийн нэр	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	зөрүү	хувиар
Төрийн сан		4.9	4.9	
Төрийн өмчийн үйлдвэрийн газар	992.30	777.9	-214.4	78.4
Төсөвт байгууллага	1,182.70	1837.7	655	155.4
Төсөл сангууд			0	
Нийт дүн	2,175.00	2,620.50	445.5	233.78

Нийт өглөгийн 0,2 хувийг Төрийн сангийн өглөг, 29,7 хувийг ОН-ийн өмчит үйлдвэрийн газрын, 70,1 хувийг төсөвт байгууллагын өглөг эзлэж байна.

ТЕЗ-ын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар өр, төлбөртэй холбоотой дараах зөрчил, дутагдал илэрлээ.Үүнд:

- Өлгий сумын 6 дугаар бүрэн дунд сургуульд Төсвийн тухай хуулийн 6 дугаа зүйлийн 6.4.8 дахь заалтыг баримталж, 6,1 сая төгрөгийн өглөгийг бүрэн барагдуулж, шинээр өр үүсгэхгүй байх, шинээр нэмэгдсэн бага ангийн 2 бүлгийн багшийн орон тоог 2018 оны орон тооны хязгаарт оруулж батлуулах, Цэнгэл сумын 2 дугаар бага сургууль нь 97,4 мянган төгрөгийн НДШ-ийн өрийг НД-ын байгууллагатай тооцоо нийлээгүй зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өгөгдсөн.
- Өлгий сумын 7 дугаар цэцэрлэгт төсөвт дутуу төвлөрүүлсэн 0,5 сая төгрөгийн ХХОАТ, 0,8 сая төгрөгийн НДШ-ийг нөхөн төлүүлэхээр, Өлгий сумын “Эрдэм” хүүдийн цэцэрлэгт санхүүгийн тайланд дутуу харуулсан 1,8 сая төгрөгийн ХХОАТ-ыг нөхөн төлүүлэхээр акт тогтоосон.
- Аймгийн ИТХ, Булган сумын ЗДТГ, Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг, Булган сумын Хүүхдийн цэцэрлэг, Буянт сумын бүрэн дунд сургууль, Сагсай сумын бүрэн

дунд сургууль, Сагсай ЭМТөв, Улаанхус сумын Хөххөтөлийн дунд сургууль, Дэлүүн сумын бүрэн дунд сургууль, Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль, Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургууль 13 орон тоо илүү ажиллуулж, шинээр 1.4-56,8 сая төгрөгөөр өр төлбөрөө нэмэгдүүлсэн

- Булган сумын ЭМТөв нь оны эцэст эм ханган нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж, өглөгийг баталгаажуулаагүй, эм ханган нийлүүлэгч 2 компанид төлөх эмийн өглөг нь маргаантай, эмийн батлагдсан төсвөөс санхүүгийн тайланд тусгагдаагүй өнгөрсөн оны 1,8 сая төгрөгийн өрийг төлсөн, өглөг өмнөх оноос 6,1 сая төгрөгөөр нэмэгдсэн
- Өлгий сумын ИТХурал 0,2 сая төгрөгийн НДШ-ийн, Өлгий сумын ЗДТГ 5,6 сая төгрөгийн ХХОАТ-ын өмнөх оны тайланд тусгагдаагүй өрийг тайлант оны төсвөөс төлсөн.
- Ногооннуур сумын бүрэн дунд сургууль нь орон тоог хэтрүүлж, ажилчдын гарт олгох цалингаас НДШ-ийн байгууллагаас төлөх 11 хувийг илүү сутгаж, өглөгийг барагдуулсан
- Нийгмийн халамжийн сан өмнөх оны өглөгөөс 309,4 сая төгрөгийг барагдуулаагүй, шинээр 639,0 сая төгрөгийн өрийг үүсгэж, оны эцэст 948,4 сая төгрөгийн өртэй гарсаныг барагдуулах зөвлөмж өгөв

Урт хугацаат өр, төлбөрийн талаар

Тайлант оны эхэнд урт хугацаат өр төлбөр 3147,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба үүний 991.0 сая төгрөг нь “Суат” ХХК-ны Азийн хөгжлийн банкинд төлөх урт хугацаат зээл, 2136,6 сая төгрөг нь Цахилгаан шугам сүлжээний газрын Дэлхийн банкинд төлөх урт хугацаат зээлийн төлбөр, 20,0 сая төгрөг нь “Хала-Өркени” ОНӨААТҮГ-ын зээл байна.

Тайлант хугацааны эцэст 3485,7 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөр байгаа нь оны эхний өр төлбөр дээр “Жана-Өлке” ОНӨААТҮГ-ын 200,0 сая төгрөгийн урт хугацаат зээл болон хувь хүмүүст олгосон 138,0 сая төгрөгийн зээлийг е-тайланд богино хугацаат өр төлбөр, урьдчилж орсон орлого дансанд бүртгэснийг урт хугацаат өр төлбөрийн дансанд шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Арван хоёр. Орлогын бүртгэл, тайлагнал

2017 оны ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаарх үйл ажиллагааны орлогын нийт дүн 84,158,7 сая төгрөг бөгөөд өмнөх онтой харьцуулахад 1,544.0 сая төгрөгөөр өссөн байна.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Зөрүү
Татварын орлого	6,481.30	7,636.20	1 154.9
Татварын бус орлого	24,785.40	11870.6	-12914.8
Тусламж санхүүжилтийн орлого	54,436.10	64651.9	10215.8

Улсын төвлөрсөн төсвөөс	46,329.80	49026.9	2697.1
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,305.50	1251.4	-1,054.1
Орон нутгийн төсвөөс санхүүжих	5,077.40	12106.3	7028.9
Орон нутгийн хөгжлийн сангаас		1654.4	1654,4
Төсвийн захирагчаас	15.50		-15,4
НД-ын сангаас	707.9	612.8	-95.10
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	85,702.80	84,158.7	1,544.0

Нийт орлогын 7636,2 сая төгрөгийг татварын орлогоос, 11870,6 сая төгрөгийг татварын бус орлогоос, 64651,9 сая төгрөгийг тусламж санхүүжилтийн орлого бүрдүүлсэн байна.

Тусламж санхүүжилтийн орлогын 49026,9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс, 1654,4 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн орлогоос, 12106,3 сая төгрөгийг улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс, 1251,4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтийн орлогоос, 612,8 сая төгрөгийг НД-ын сангаас тус тус хүлээн авсан байна.

Аймгийн 2017 оны Орон нутгийн төсвийн орлого 18,929.1 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 20,385.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 7,7 хувиар буюу 1456,6 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Татварын орлогоос нийтдээ 6156,5 сая төгрөг оруулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 7614,5 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 123,7 хувиар буюу 1384,1 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Үүнээс: хувь хүний орлогын албан татвар 121,8 хувиар, дотоодын бараа үйлчилгээний татвар 108,8 хувиар, байгалийн нөөц ашигласны төлбөр 256,8 хувиар, татварын бус орлого 106,9 хувиар давж биелэгдэж, өмчийн татвар 20,1 хувиар, бусад татвар 1,9 хувиар, хөрөнгийн орлого 54,6 хувиар тасарсан байна.

Татварын бус орлогын 10,0 хувь нь төсөвт байгууллагын өөрийн орлого, 90,0 хувь нь хүү, торгууль, бусад байна.

Орон нутгийн татварын орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/сая /төгрөгөөр/

1	ᠶᠡᠨᠡᠭᠡᠨᠠᠨᠢ ᠶᠡᠨᠡᠭᠡᠨᠠᠨᠢ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	
				дүнгээр	хувиар
	НИЙТ ОРЛОГО	18,929.1	20,385.7	1,456.6	107.7
	УРСГАЛ ОРЛОГО	6,746.0	8,244.5	1,498.5	122.2
	ТАТВАРЫН ОРЛОГО	6,156.5	7,614.5	1,384.1	123.7

Баян-Өлгий аймгийн ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Орлогын албан татвар	4,757.4	5,794.5	1,037.1	121.8
ХАОАТатвар	4,757.4	5,794.5	1,037.1	121.8
Орлогын албан татвар	5,418.7	6,036.6	617.9	111.4
Үйл ажиллагааны орлого	392.8	812.1	419.3	206.7
ШУУЗУБТБАЗБүтээх орлогын татвар	3.1	3.0	(0.1)	96.8
ХХОАТатварын буцаан олголт	(1,057.2)	(1,057.2)	-	100.0
Өмчийн татвар	319.9	255.6	(64.3)	79.9
Өмчийн татвар	247.2	207.8	(39.4)	84.1
Ажлын гэрээний татвар	72.7	47.8	(24.9)	65.7
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	314.3	342.0	27.7	108.8
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	314.3	342.0	27.7	108.8
Бусад татвар	467.5	458.8	(82.6)	98.1
Орлогын татвар	328.5	237.1	(91.4)	72.2
Ажлын гэрээний татвар	102.9	112.9	10.0	109.7
Орлогын татвар	31.1	34.3	3.2	110.3
Хог хягдалын үйлчилгээний хураамж	5.0	0.6	(4.4)	12.0
бусад татвар		73.9		
Байгалийн нөөц ашигласны төлбөр	297.4	763.6	466.2	256.8
Ус, рашаан ашигласны төлбөр	50.0	16.8	(33.2)	33.6
Байгалийн хэрэглээний татвар, орлогын татвар	45.0	30.7	(14.3)	68.2
Байгалийн ургамлын НАТөлбөр		0.2	0.2	
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	202.4	715.9	513.5	353.7
II.Татварын бус орлого	589.5	630.0	40.5	106.9
Хүүгийн орлого	270.0	18.1	(251.9)	6,7
Торгуулийн орлого		292.1	292.1	
Төсөвт газрын өөрийн орлого	53.4	63.0	9.6	118.0
Бусад нэр заагдаагүй орлого	266.1	256.8	(9.3)	96.5
Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО	76.8	34.9	(41.9)	45,4
Хөрөнгө худалдсаны орлого	76.8	24.7	(52.1)	32,2
Өмч хувьчлалын орлого		10.2		

В.ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	12,106.3	12,106.3	-
1.Улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэг	12,106.3	12,106.3	
2.Урьд оны давсан орлогоос санхүүжих			-

ХХОАТатвар нийт дүнгээр 1037,1 сая төгрөгөөр давж биелэгдсэний дотор цалин, түүнтэй адилтгах орлогын албан татвар 617,9 сая төгрөгөөр, үйл ажиллагааны орлогын албан татвар 419,3 сая төгрөгөөр давж биелэгдсэн байна.

Дотоодын бараа үйлчилгээний татвар 27,7 сая төгрөгөөр давж биелэгдсэн нь байна. Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс 466,2 сая төгрөгийн орлого давж биелэгдсэний дотор агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөрлийн хураамжийн орлогыг 513,5 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Тухайлбал: Алтай сум ангийн орлогыг 77,5 сая төгрөгөөр, Бугат сум 22,1 сая төгрөгөөр, Булган сум 125,9 сая төгрөгөөр, Буянт сум 121,8 сая төгрөгөөр, Дэлүүн сум 104,9 сая төгрөгөөр, Толбо сум 44,7 сая төгрөгөөр, Улаанхус сум 12,8 сая төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 118,0 хувиар буюу 9,6 сая төгрөгөөр давж биелэгджээ. Улсын төсвөөс 12106,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авсан байна.

Сумуудын ОН-ийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сум тус бүрээр харуулбал: /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	2017 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Алтай	27,813.8	139,790.7	111,976.9	502.6
2	Алтанцөгц	15,744.2	18,676.4	2,932.2	118.6
3	Баяннуур	21,711.0	28,103.5	6,392.5	129.4
4	Бугат	45,270.0	72,260.0	26,990.0	159.6
5	Булган	63,968.9	205,228.8	141,259.9	320.8
6	Буянт	62,314.8	182,689.5	120,374.7	293.2
7	Дэлүүн	79,510.0	193,513.2	114,003.2	243.4
8	Ногооннуур	27,030.1	47,757.3	20,727.2	176.7
9	Сагсай	28,796.6	34,135.3	5,338.7	118.5
10	Толбо	23,648.6	94,265.0	70,616.4	398.6

11	Улаанхус	75,719.9	107,311.7	31,591.8	141.7
12	Цэнгэл	49,401.9	54,739.4	5,337.5	110.8
13	Цагааннуур	5,616.0	10,060.6	4,444.6	179.1
14	Өлгий	308,806.6	635,574.7	326,768.1	205.8
15	Татварын хэлтэс	5,987,446.4	6,455,315.9	467,869.5	107.8
	БҮГД	6,822,798.8	8,279,422.0	1,456,623.2	121.3

Орон нутгийн татварын орлогын төлөвлөг бүх сум жигд ханган биелүүлсэн байна. Алтай, Булган, Буянт, Толбо, Дэлүүн сум орлогын төлөвлөгөөг 293,2-502,6 хувиар давуулан биелүүлсэн нь ангийн орлого давж биелэгдсэнтэй холбоотой байна.

Сумдын ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар сумдын орлогын бүрдүүлэлт зарцуулалтанд хийсэн аудитаар агнуурын нөөц ашигласны болон байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орсон 54,3 сая төгрөгийг сумын орлогын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Бугат сумын Засаг дарга “Монгол Сафари” ХХК-наас төлсөн 30,1 сая төгрөгийн ан агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг сумын нөөцийн төлбөрийн дансанд оруулж, орон нутгийн ерөнхий орлогын дансанд оруулсан боловч төсвийн орлогын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, мөн 19,0 сая төгрөгийн агнуурын нөц ашигласны төлбөрийг Хаан банкин данс нээж, төсвийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлэлгүй шууд зарцуулж, сумын дүнгээр 49,5 сая төгрөгийг орон нутгийн орлогын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй байна.
- Ногооннуур сумын Засаг дарга “Фишекс”, “Эйшиа миллионс” ХХК-наас байгалийн нөөц ашигласны төлбөрөөс орсон 4,8 сая төгрөгийн барагшууны орлогыг сумын байгаль орчныг нөхөн сэргээх тусгай сангийн барьцаа дансанд оруулсан боловч орон нутгийн ерөнхий орлогын дансанд оруулаагүй, орлогын гүйцэтгэлийг дутуу тайлагнасан байна.

Арван гурав. Зардлын бүртгэл, тайлагнал

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайланд нийт зардал 100248,9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч өмнөх оноос 17089,9 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Нийт зардлыг бүтцээр нь харуулбал:

/сая төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	ЭЗЛЭХ ХУВЬ
----------	----------	------------	------------

НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	83,159.00	81,673.0	120.6
УРСГАЛ ЗАРДАЛ	83,078.10	80,384.1	120.7
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,624.10	62,572.1	97.2
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	35,936.90	36,001.50	100.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,033.30	4,099.50	101.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,779.20	4,689.80	69.2
Хангамж, бараа материалын зардал	1,225.60	1778,1	145,1
Нормативт зардал	3,644.90	3,800.80	104.3
Эд хогшил, урсгал засварын зардал	284.8	241.4	84.8
Томилолт, зочны зардал	184.2	221.1	120.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1800.8	3,000.6	166,6
Бараа үйлчилгээний бусад зардал	9,734.40	8,739.3	89.8
ТАТААС	30.6	77.3	252.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,074.50	1,288.9	31.6
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,348.90	17734,7	115.5

Нийт зарлагын 76,6 хувийг бараа үйлчилгээний зардал, 1,6 хувийг хөрөнгийн зардал, 21,7 хувийг урсгал шилжүүлэг, 0,1 хувийг татаас санхүүжилт эзлэж байна.

Бараа үйлчилгээний зардалтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

ТШЗ-ын тайлан, ТТЗ-ийн тайлангаар нийтдээ 54,4 сая төгрөгийн зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр акт тогтоосны бараа үйлчилгээний зардалтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- Сагсай сумын бүрэн дунд сургууль 1,7 сая төгрөгийг, Өлгий сумын 3 дугаар бүрэн дунд сургууль 0,5 сая төгрөг, Толбо сумын бүрэн дунд сургууль 1,1 сая төгрөгийг үдийн цайны санхүүжилтийг гүйцэтгэлээс илүү шилжүүлсэн,
- Цагааннуур тосгоны захирагчийн алба, Баянуур сумын ЭМТ, Улаанхус сумын бүрэн дунд сургууль, Согоог дунд сургууль, Хүүхдийн цэцэрлэг, сумын ЗДТГ, Алтанцөгц сумын ЗДТГ, Ногооннуур сумын бүрэн дунд сургууль, сумын ЗДТГ, Толбо сумын

бүрэн дунд сургууль, Хот тохижуулах алба, Толбо сумын ЗДТГ 43 хүнд 10.8 сая төгрөгийн урамшуулалыг сахилгын шийтгэл хүнд олгосон,

- Баяннуур сумын бүрэн дунд сургууль 7,1 сая төгрөгийн, Толбо сумын бүрэн дунд сургууль 3,3 сая төгрөгийн, Өлгий сумын 10 дугаар цэцэрлэг 0,3 сая төгрөгийн, Бугат сумын Засаг дарга нь 4,9 сая төгрөгийн төсвийн хөрөнгийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар зориулалт бус зарцуулсан,
- Баяннуур сумын Засаг дарга нь Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөнөөс 5,0 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсаныг тус тус нөхөн төлүүлэхээр акт тотоов.
- Бугат сумын Засаг дарга ан агнуурын нөөцийн төлбөрөөс орсон 30.1 сая төгрөгийг сумын ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансаар ИТХурлын тогтоол, шийдвэр гаргуулахгүйгээр, Засаг даргын захирамжаар, 19.0 сая төгрөгийг Засаг даргын баталсан өр барагдуулах жагсаалтыг үндэслэн төсвийн хууль тогтоомж зөрчиж шууд зарцуулж ЗДТГ-ын төсвийн зарлагын гүйцэтгэл, Сумын төсвийн нэгдсэн зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, зарлагын гүйцэтгэлийг дутуу тайлагнаж эрх хэмжээгээ хэтрүүлсэн.
- Ногооннуур сумын Засаг дарга 4,8 сая төгрөгийн барагшууны орлогыг ЗДТГазрын нэмэлт санхүүжилтийн дансанд оруулж Засаг дарга 1 дүгээр гарын үсэг зурж агнуурын нөөц тогтоох гэрээний урьдчилгаанд 2.1 сая төгрөгийг, Засаг даргын орлогчийн захирамжаар 1.0 сая төгрөгийг багийн өдөрлөгт, 1.7 сая төгрөгийг ЗДТГазрын тээвэр шатахууны зардалд зарцуулж, орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэлд оруулж тайлагнаагүй, эрх хэмжээгээ хэтрүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн харьяа байгууллагуудаас бүртгэл тайлагналтай холбоотой дараах алдаа зөрчил илэрсэн.Үүнд:

- Бугат сумын бүрэн дунд сургууль нь тайлант онд БСШУ-ны яамнаас үнэ төлбөргүй олгосон 78,2 сая төгрөгийн бараа материал, үндсэн хөрөнгө, их засварыг орлого авч тайлагнаагүй,
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар 5,0 сая төгрөгийн бохир гүйлгээг төсвийн гүйцэтгэлээс цэвэрлээгүй,
- Биеийн тамир спортын газар санхүүгийн байдлын тайлант үеийн үр дүнг 1,8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Бугат сумын ТТЗНСТ-д сумын нэгтгэсэн тайланд орох ОНХ сан, СХСан, төрийн сангуудын тайланг гаргаж ирүүлээгүй, е-тайланд зөрүүтэй тайлагнаж ирүүлсэн байна.
- Өлгий сумын ИТХ нь жижиг мөнгөн сангийн гүйлгээг Өлгий сумын ЗДТГ-ын дансаар дамжуулан хийж ирсэн,
- Баяннуур сумын бүрэн дунд сургууль 3 дугаар сарын харилцахын баримтыг аудитад ирүүлээгүйгээс тайлант оны орлого, зардлын нийт дүнг баталгаажуулах хангалттай нотлох зүйл цуглуулж чадаагүй,
- Баяннуур сумын Эрүүл мэндийн төв цалингийн зардлын гүйцэтгэлийг 13,5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан,
- Аймгийн ИТХ ИТХ-ын төлөөлөгч Н.Бейбитханд сургалтын зардалд олгосон 5,0 сая төгрөгийн анхан шатны баримтыг хавсаргаагүй,
- Булган сумын ЗДТГ ЗД-ын захирамжаар сумын ойн баярт зарцуулсан 2,0 сая төгрөгийн анхан шатны баримтыг бүрдүүлээгүй,
- Өлгий сумын ИТХ 7,6 сая төгрөгийн, сумын ЗДТГ 81,9 сая төгрөгийн ажил гүйлгээний анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн,

- Булган сумын Ёлт хүүхдийн цэцэрлэг нь хоолны зардлын төсвөөс цалингийн зардалд төрийн сангийн зөвшөөрөлгүйгээр 3,5 сая төгрөгийг, Булган сумын ЗДТГ нь шатахууны зардлаас 1,8 сая төгрөг, түлшний зардлаас 4,7 сая төгрөгийг, Баяннуур сумын Эрүүл мэндийн төв нь хоол, эм, түлш, шатахууны зардлаас 4,0 сая төгрөгийг, Буянт сумын ЗДТГ 7,2 сая төгрөгийг, Уланхус сумын төсөвт байгууллагууд 25,4 сая төгрөгийг төрийн сангийн зөвшөөрөлгүй гүлгэн зарцуулсан.
- Өлгий сумын 3, 5 дугаар бүрэн дунд сургууль Боловсролын тухай хуулинд заагаагүй хүмүүжлийн эрхлэгчийн орон тоог ажиллуулсан,
- Булган сумын Ёлт цэцэрлэг, Алтай сумын цэцэрлэг, Өлгий сумын 5, 13, 17 дугаар цэцэрлэг нь 5,4 сая төгрөгийн хоолны зардлыг нэг хүүхдийн хоолны нормативаас илүү зарцуулсан
- Асрамжийн газар Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.8 дахь заалтын дагуу асруулагчийн тэтгэврийн 30 хувийг асруулагчдын тэтгэвэр, тэтгэмжээс суутган авч, байгууллагын хэрэгцээнд зарцуулсан боловч орлого, зардалд тусгаж харуулаагүй,
- Бугат сумын Засаг дарга нь ТТЗ-ийн тайлангаа хуулийн хугацаанаас 20 хоногоор хоцроож ирүүлсэн, тайлангаа пластик программар нэгтгэж ирүүлээгүй, е-тайлангаарх тайланд урсгах бичилт хийгээгүй, сумын ОНХСан, СХСан, Төрийн сангуудын тайланг гаргаж ирүүлээгүй.

Арван дөрөв. Эзэмшигчийн өмч, хуримтлагдсан үр дүнгийн талаар

ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 111,247.4 сая төгрөг байна. Үүнээс ЗГОКапитал 54732.6 сая төгрөг, ТӨҮГ-ын өмчийн дүн 3528,1 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 25774,2 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 27212,5 сая төгрөг байна. ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 2135,7 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн 27212,5 сая төгрөг болж өссөн байна.

Арван тав. Тусгай зориулалтын шилжүүлгийн талаар

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ” гэж заасан. Үүнд:

- Ерөнхий боловсрол
- Сургуулийн өмнөх боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ
- Газрын харилцаа, кадастр
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

15.1 ТЗШ-ийн байгууллагуудын мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 2017 оны эцэст нийтдээ 43,1 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарч оны эхнээс 41,8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

/мөнгөн хөрөнгийн үлдэгдэл бага тоогоор гарч байгаа тул үлдэгдлийг мянган төгрөгөөр гаргав/

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Кассад байгаа бэлэн мөнгө	Банкинд байгаа бэлэн мөнгө	
				Арилжааны банк	Төрийн сангийн нэгдсэн данс
Кассад байгаа бэлэн мөнгө	12,1	4350,0	4350,0		
Төгрөг/ЖМС	12,1	4350,0	4350,0		
Банкинд байгаа бэлэн мөнгө	1284,5	38739,3	0	38739,3	
Төгрөг	1284,5	38739,3	0	38739,3	
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	1296,6	43089,3	778.8	517.8	

Мөнгөн хөрөнгийн 10,1 сая төгрөгийг кассад байгаа бэлэн мөнгө, 89,9 сая төгрөгийг арилжааны банкинд байгаа мөнгөний үлдэгдэл эзлэж байна.

15.2. Авлагын бүртгэл, тайлагнал

Тусгай шилжүүлгийн байгууллагуудын авлагын бүтэц дараах байдалтай байна.

/сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
Ажиллагчидтай холбогдсон авлага	23,1	15,4	-7,7	27,5
Төлбөртэй үйлчилгээний авлага				
Татаас санхүүжилтийн авлага	5,9	0,5	-5,4	0,9
Татвар, НДШ – ийн авлага				
Бусад авлага	74,5	40,0	-35,4	71,6
Байгууллагаас авах авлага	68,7	34,7	-34,0	62,1

Хувь хүмүүсээс авах авлага	5,8	5,3	-0,3	9,5
Нийт авлагын дүн	103,5	55,9	-47,6	100.0
<i>Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:</i>				
ЕБСургуулиуд, соёлын төв, СӨБ	96,5	55,0	-41,5	98,4
ЭМСалбар	1,1	0,4	-0,7	0,7
ГХБХБГазар	5,9	0,5	-5,4	0,9
ХГБХХ	-	-		
ДҮН	103,5	55,9	-47,6	100

Авлагын үлдэгдэл өмнөх оноос 47,6 сая төгрөгөөр буурсан байна. Оны эцсийн нийт авлагын 15,4 сая төгрөгийг ажиллагчидтай холбогдсон авлага, 0,5 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлага, 34,7 сая төгрөгийг байгууллагаас авах авлага, 5,3 сая төгрөгийг хувь хүмүүсээс авах авлага эзэлжээ. Нийт авлагын 98,4 хувийг ЕБСургууль, СӨБ, соёлын төвүүдийн авлага, 0,7 хувийг ЭМСалбарын авлага, 0,9 хувийг ГХБХБГазрын авлага эзлэж байна.

15.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд бараа материалын эцсийн үлдэгдэл 2926,6 сая төгрөгөөр тайлагнагдаж, оны эхнээс 141,1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. /сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
БАРАА МАТЕРИАЛ	2,785.40	2,926.60	141.20	105.1
Түүхий эд материал	113.0	105.4	-7.60	93.3
Тусгай зориулалттай материал	58.8	52.8	-6.00	89.8
Эм боох материал	54.2	52.6	-1.60	97.0
Дуусаагүй үйлдвэрлэл	19.2	42.8	23.60	222.9
Бэлэн бүтээгдэхүүн	51.7	49.3	-2.40	95.4
Хангамжийн материал	2,536.20	2,678.10	141.90	105.6
Бичиг хэргийн материал	54.2	61.9	7.70	114.2
Аж ахуйн материал	1182.3	1,296.80	114.50	109.7
Сэлбэг хэрэгсэл	4.0	5.0	1.00	125.0
Түлш, шатах тослох материал	176.7	146.3	-30.40	82.8
Барилгын засварын материал	15.9	10.3	-5.60	64.8
Хүнсний материал	443.0	401.7	-41.30	90.7

Бусад хангамжийн материал	660.1	756.0	95.90	114.5
Мал амьтад	65.3	51.1	-14.20	78.3

Нийт бараа материалын үлдэгдэлд түхий эд материал 3,6 хувийг, хангамжийн материал 91,5 хувийг, 1,5 хувийг дусаагүй үйлдвэрлэл, 1,7 хувийг бэлэн бүтээгдэхүүн, 1,7 хувийг мал амьтад эзэлж байна.

Бараа материалын жилийн эцсийн үлдэгдлийн 90,0 хувийг Боловсрол, соёлын салбарын, 9,1 хувийг буюу ЭМСалбарын, 0,8 хувийг ГХБХБГазрын, 0,1 хувийг ГБХЗХГ-ын бараа материалын үлдэгдэл эзлэж байна.

15.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

ТЗШ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар үндсэн хөрөнгө бүтэц дараах байдалтай байна. /сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	63,281.40	64,118.30	836.90	100
Биет хөрөнгө	63,272.90	64,111.50	838.60	99.99
Биет бус хөрөнгө	8.5	6.8	-1.70	0.01

Нийт үндсэн хөрөнгийн 99,99 хувийг биет хөрөнгө, 0,01 хувийг биет бус хөрөнгө эзлэж байна.

15.5 .Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Тусгай зориулалтын шилжүүлгийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өглөг 566,8 сая төгрөгөөрт хүрч, өмнөх оноос 304,6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Өглөгийн үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	хувь
НИЙТ ӨР ТӨЛБӨР	262.2	566.84	304.64	216.2
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	262.2	566.84	304.64	216.2
Өглөг	146	412.5	266.5	282.5
Ажилчидтай холбогдсон өглөг	48.9	247.7	198.8	506.5
Бараа үйлчилгээний зардлын өглөг	97.1	164.8	67.7	169.7
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг			0	
Бусад өглөг	116.2	154.34	38.14	132.8
Байгууллагад төлөх өглөг	109.9	149.4	39.5	135.9
Хувь хүмүүст төлөх өглөг	4.9	4.4	-0.5	89.8

Татварын өглөг		0.04	0.04	
НДШ - ийн өглөг	1.4	0.5	-0.9	35.7

Оны эцэст Боловсрол, соёлын салбар нь 505,9 сая төгрөгийн, ЭМСалбар нь 59,7 сая төгрөгийн, ГХБХБГазар 1,2 сая төгрөгийн өглөгтэй байна.

15.6 Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт

Тусгай зориулалтын шилжүүлгийг байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

(сая.төгрөгөөр)

Үзүүлэлт	Нийт дүн				
		БСШУ-ын сайд	ХАХНХ-ын сайд	БХБСайд	ЭМС-ын сайд
Батлагдсан төсөв	49,072.20	44,780.50	101.40	224.40	3,965.90
Олгосон урсгал санхүүжилт	49,028.00	44,736.30	101.40	224.40	3,965.90
Нийт төвлөрүүлсэн	18.60	17.60		0.50	0.50
Үүнээс: Төсөвт /Сангийн яам/	-				
Өглөгт тооцсон	566.80	505.90	-	1.20	59.70

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлэгт 49072,2 сая төгрөгийн төсөв батлагдаж, 49028,0 сая төгрөгийг зарцуулж, 18,6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Арван зургаа. Орон нутгийн хөрөнгө оруулалтын талаар

Аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит IV дүгээр хуралдааны 16 тоот тогтоолын 6 дугаар хавсралтаар 2016 оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэхээр хөрөнгө оруулалтын 29 төсөл арга хэмжээнд 416,3 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилсан байна. Үүнээс 397,1 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 19,2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, гүйцэтгэлээх 395,7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Замын сангийн хөрөнгийг 224,5 сая төгрөгөөр баталж, 178,9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 44,8 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 0,8 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлэхээр тусгасан байна. Үүнээс тайлант онд 198,6 сая төгрөгийг зарцуулж, 25,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт

Аймгийн ИТХурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн III дугаар хуралдааны 12 тоот тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийн нийт дүнг 2052.0 сая төгрөгөөр баталжээ. Үүнээс сумдын ОНХСанд 653.9 сая төгрөгийн, аймгийн ОНХСанд 955,1 сая төгрөгийн, ОНХ сангаас олгох суурь зарлагад /ЗДТГ-т олгох шилжүүлэг/ 443,1 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилжээ.

Төсвийн тодотголоор ОНХНСангаас авах орлогын шилжүүлгийг 1654,4 сая төгрөгөөр баталж, сумдад 842,7 сая төгрөгийн, аймагт 827,7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна. Энэ нь анх батлагдсан төсвөөс 397,6 сая төгрөг буюу 19,4 хувиар буурсан байна.

Гүйцэтгэлээр ОНХСангийн санхүүжилтэнд 1654,3 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 29,3 сая төгрөг бүгд 1683,6 сая төгрөгийн санхүүжилтийн авсан байна. Үүнээс Хот тохижуулах алба, сумын ОНХСан, МЭҮ-ний зардалд нийтдээ 1048,8 сая төгрөг, аймгийн ОНХСанд 634,8 сая төгрөг олгосон байна.

ОНХСангийн оны эхний үлдэгдэл 429.9 сая төгрөг ба 1683.6 сая төгрөгийн орлого хүлээн авч аймаг, сумын ОНХСанд 2,037.5 сая төгрөг хуваарилж, оны эцэст 76.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс аймгийн ОНХ сан 1,2 сая төгрөгийн, сумын ОНХСангийн 74,8 сая төгрөгийн үлдэгдэл байна.

Арван долоо. Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн нийцлийн аудитаар нийтдээ 51367.3 сая төгрөгийн зөрчил илэрч, аймгийн Засаг даргад зөрчил гаргасан төсвийн байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага өгөгдөж, биелэлтийг гаргаж ирүүлсэн.

Арван найм. Аудитын дүнгийн талаар

18.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлд 10 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 40 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

18.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн

тайланд нөлөөлөхүйц хэмжээний орон нутгийн орлого, орлогын ерөнхий данс, санхүүжилт орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. Нэгтгэлд орсон байгууллагуудын санхүүгийн тайланг е-тайлантай тулгаж зөрүүг арилган ажилласан байгаа болно. /ТАБ-СТА-В-3/

18.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна. Үүнд:

1. Аймгийн Орон нутгийн харьяа төсөвт байгууллагуудын батлагдсан төсөвт орон тооны хязгаарыг 589.5 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 630 хүн ажиллуулж орон тооны хязгаарыг 40.5-аар хэтрүүлжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.3-т “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 65 дугаар зүйлийн 65.1.8-д “тухайн шатны төсвийн байгууллагын орон тоог төсвийн захирагч бүрээр батлах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: *Төсөвт байгууллагууд батлагдсан орон тооны хязгаарыг мөрдөж ажиллахыг зөвлөмж болгов.*

2. Аймгийн Орон нутгийн харьяа төсөвт байгууллагууд оны эцэст 1501.0 сая төгрөгийн өглөгтэй гарч өглөг 668.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: Орон нутгийн төсвийн байгууллагууд 1053.6 сая төгрөгийн, Боловсрол, соёлын салбарын байгууллагууд 388.2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн салбарын байгууллагууд 59.7 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2-т “өр, авлага үүсгэхгүй байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: *өр төлбөр нэмж үүсгэхгүй байх, он дамжсан өр төлбөрийг бүрэн барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг зөвлөмж болгов.*

3. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны жилийн эцсийн Э-тайлан дахь санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэл, аудит хийсэн санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэлээс зөрүүтэй байна. Тухайлбал: Мөнгөн хөрөнгө 0.001 сая төгрөгөөр, авлага 42.6 сая төгрөгөөр, бараа материал 3.6 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгө 429.0 сая төгрөгөөр, өр төлбөр 54.2 сая төгрөгөөр, Засгийн газрын оруулсан капитал 369.7 сая төгрөгөөр, хуримтлагдсан үр данс 154.7 сая төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь зарим байгууллагууд 2016 оны жилийн эцсийн аудит хийсэн санхүүгийн тайланг Э-тайлан программд зөв шивж оруулаагүй, Сумын санхүүгийн алба, Санхүү төрийн сангийн хэлтэс Э-тайлан программд харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг зөв шивж оруулсан эсэхийг хянаж, баталгаажуулаагүй байгаатай холбоотой ба ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэх, тулган баталгаажуулах ажилд хүндрэл учруулж байна. Дээрхи асуудал нь Төсвийн тухай хуулийн 54.2-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна", 54.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: *Байгууллагуудын аудит хийгдсэн санхүүгийн тайланг Э-тайлан программд нэг бүрчлэн тулгалт хийж, зөрүүг арилган хянан баталгаажуулж байхыг Менежментийн захидлаар зөвлөмж өгөв.*

18.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Нэгтгэлд орсон байгууллагуудын санхүүгийн тайланг Э-тайланд нэгбүрчлэн тулгаж, алдааг залруулсан тул залруулагдаагүй алдаа гараагүй байгаа болно.

18.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татах бусад чухал асуудал байхгүй болно.

18.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Байхгүй.

18.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй. Асуудлын бүртгэлийг баримтжуулав.

18.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

ТЕЗ-ийн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 заалт бүхий зөвлөмж өгөгдсөний 1 зөвлөмжийг хэрэгжүүлж 2 зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна. Дараах зөвлөмжүүд бүрэн хэрэгжээгүй байна.

1. Төсөвт байгууллага, орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн Засгийн газрын е-тайлан цахим системд аудитлагдсан санхүүгийн тайланг алдаагүй, үнэн зөв шивж оруулсан эсэхийг сумын санхүүгийн алба болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн зүгээс давхар хянан баталгаажуулж, илэрсэн алдаа зөрчлийг тухай бүрт нь арилгаж ажиллах;

2. Төсвийн тухай хуулийн 26.1-д заасан “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтлөнө” гэсэн заалтыг хэрэгжүүлж Төсвийн байгууллагуудад хэрэглэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдүүлэх ажлыг хийж, хэрэгжүүлэх, УСНББОУС-ыг бүрэн нэвтрүүлэх, сумын санхүүгийн алба, нягтлан бодогч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, мэргэжил ур чадварыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах;

18.9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүнгийн талаар

Аймгийн аудитын газраас төсвийн байгууллага, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийх баталгаажуулах аудитын төлөвлөгөөнд төсвийн шууд захирагч 102, аж ахуйн нэгж 4, тусгай сан 3, төвлөрүүлэн захирагч 14, төсвийн ерөнхийлөн захирагч 1 бүгд 132 санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргахаар, 70 төсвийн шууд захирагч, төсөл сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулахаар төлөвлөж, 37 байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлж өнжөөхөөр тусгагдсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн харьяа байгууллагуудаас нийтдээ 2179,3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч үүнээс 460,1 сая төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийж, 46,5 сая төгрөгийн зөрчил төлбөрийн акт тогтоож, 1384,4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 229,7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 16 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.

Аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн 42.6 хувийг нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой, 41.9 хувийг хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 6.4 хувийг дотоод хяналт, хариуцлагатай холбоотой, 9,1 хувийг бусад төрлийн алдаа зөрчлүүд эзэлж байна.

Аудитын дүнгээр 102 санал дүгнэлт гаргасан ба үүнээс 87 санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт, 14 санхүүгийн тайланд нь хязгаарлалттай санал дүгнэлт өгч, 1 санхүүгийн тайланд сөрөг санал дүгнэлт өгөв.

Тайлант онд орон тоо хэтрүүлсэн, шинээр өр үүсгэсэн, илэрсэн алдаа зөчрлийн дүн материаллаг түвшингээс их дүнтэй Булган, Баяннуур, Сагсай сумын ЭМ-ийн төв, Булган, Толбо сумын хүүхдийн цэцэрлэг, Дэлүүн, Сагсай, Баяннуур, Буянт сумын бүрэн дунд сургууль, Өлгий сумын 1, 4 дүгээр бүрэн дунд сургууль, , “Хала өркени” ОНӨААН, Ногооннуур сумын ТТЗ-ийн СНТ-д хязгаарлалттай санал дүгнэлт өгсөн.

Бугат сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангаа зааварын дагуу гаргаагүй, СНТ-ийн устгах бичилт хийгдээгүй дүнгээр алдаатай гаргаж, тайлангийн тэмдэглэл тодруулгыг Сангийн Сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй тул сөрөг санал дүгнэлт өгсөн болно.

“Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Хязгаарлалттай” санал,дүгнэлт авсан байгууллага	“Хязгаарлалттай” санал, дүгнэлтийн шалтгаан
1	Булган сумын ЭМТөв	<ul style="list-style-type: none"> Оны эцэст эм ханган нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж, өглөгийг баталгаажуулаагүй, эм ханган нийлүүлэгч 2 компанид төлөх эмийн өглөг нь маргаантай.Эмийн батлагдсан төсвөөс санхүүгийн тайланд тусгагдаагүй өнгөрсөн оны 1824.1 мянган төгрөгийн өглөгийг төлсөн. Оны эцэст 11879.9 мянган төгрөгийн өглөгтэй гарч, өглөг оны эхнээс 6080.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн.
2	Баяннуур сумын ЭМТөв	<ul style="list-style-type: none"> Цалингийн зардлын гүйцэтэлийг 13.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж, Эм нийлүүлсэн компаниудтай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй, хоол, эм, түлш шатахууны зардлаас 4,0 сая төгрөгийг зохих зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулсан, жилийн эцэст тооллого хийсэн материал ирүүлээгүй
3	Сагсай сумын ЭМтөв	<ul style="list-style-type: none"> Орон тоог хэтрүүлэн ажиллуулж байгаа зөрчлийг бүрэн арилгаж, орон тооны хязгаарыг мөрдөж ажиллах, өр төлбөрийг бүрэн барагдуулах.
4	Булган сумын хүүхдийн цэцэрлэг	<ul style="list-style-type: none"> Жилийн эцэст 6.8 сая төгрөгийн өрийг үүсгэж, нярав нь 2017 онд бараа материалын тайланг зохих журмаар гаргаагүй, түүнд нятглан бодогч нь хяналт тавьж ажиллагаагүй
5	Толбо сумын Хүүхдийн цэцэрлэг	<ul style="list-style-type: none"> 2017 оны эхний 3 сарын аж ахуйн санхүүгийн материалыг ирүүлээгүй учраас энэ хугацаанд зарцуулсан хөрөнгийн орлого, зарлагын тооцоог хийх хангалттай нотлох баримт цуглуулж чадаагүй
6	Дэлүүн сумын бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Сургуулийн орон тооны хязгаарыг 163 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 183 хүн ажиллуулж, орон тоог 20 хүнээр хэтрүүлсэн.Үүнээс 16 хүнийг 2017 онд шинээр ажилд авсан. Орон тоог хэтрүүлэн ажилуулсаны улмаас НДШ-д 9.1 сая төгрөгийн, ХХОАТ-т 19.5 сая төгрөгийн бүгд 28.6 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн.Урьд оноос шилжиж ирсэн 56.9 сая төгрөгийн халаалтын өрийг барагдуулаагүй.
7	Сагсай сумын бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Сургуулийн орон тооны хязгаарыг 109 хүнээр баталсан ба гүйцэтгэлээр 119 хүн ажиллуулж, орон тоог 10-аар хэтрүүлэн ажиллуулсан.Тайлант онд нийт 38.8 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсний дотор НДШ-д 4.2 сая төгрөгийн, халаалтанд 34.6 сая төгрөгийн өглөг гарсан.
8	Баяннуур сумын бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Сургуулийн 2017 оны 3 дугаар сарын харилцахын баримтыг аудитад ирүүлээгүйгээс тайлант оны орлого, зардлын нийт дүнг баталгаажуулах хангалттай нотлох зүйл цуглуулж чадаагүй, Жилийн эцэст тооллого хийсэн боловч тооцоог бодож, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулаагүй

9	Буянт сумын бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Илүү орон тоо ажиллууснаас тайлант онд шинээр 6,8 сая төгрөгийн өрийг үүсгэж, аймгийн төрийн сангийн зөвшөөрөлгүйгээр 16,9 сая төгрөгийг төсвийн зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.
0	Өлгий сумын 4 дүгээр бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Оны эцэст нийгмийн даатгалын шимтгэлд 17.4 сая төгрөгийн, халаалтанд 20.6 сая төгрөгийн, гэрэл цахилгаанд 1.4 сая төгрөгийн, үдийн цайд 1.5 сая төгрөгийн нийтдээ 40,9 сая төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн
11	Өлгий сумын 1 дүгээр бүрэн дунд сургууль	<ul style="list-style-type: none"> Тайлант онд 13 орон тоог илүү ажиллуулж, шинээр 51,8 сая төгрөгийн өрийг үүсгэсэн.
12	Хала өркени ОНӨААН	<ul style="list-style-type: none"> 2017 онд үндсэн хөрөнгийн бүтэн жилийн тооллого хийгээгүй Урьд оноос шилжиж ирсэн 79.4 сая төгрөгийн өрийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна. Санхүүгийн тайланд 7.6 сая төгрөгийн орлогыг тайлант үеийн орлого, авлагад дутуу тусгасан.
13	Ногооннуур сумын ТТЗ-ийн СНТ	<ul style="list-style-type: none"> Ногооннуур сумн Засаг дарга нь байгалийн нөөц шигласны төлбөрөөс орсон 4,8 сая төгрөгийн орлогыг орон нутгийн орлогын ерөнхий дансанд оруулалгүй ЗДТГ-ын нэмэлт дансанд оруулж, сумын ИТХ-ын тогтоол шийдвэргүйгээр зарцуулсан.

“Сөрөг” санал дүгнэлт авсан байгууллагын жагсаалт:

№	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан” байгууллага	“Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан ” шалтгаан
1	Бугат сумын ТТЗ-ийн СНТ	<ul style="list-style-type: none"> Бугат сумын ТТЗ-ийн санхүүгийн тайланд санхүүгийн тайлангаа зааварын дагуу гаргаагүй, СНТ-ийн устгах бичилт хийгдээгүй дүнгээр алдаатай гаргаж, тайлангийн тэмдэглэл тодруулгыг Сангийн Сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэж ирүүлээгүй

18.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, менежментийн захидал 37 хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
ОГНОО:2018.04.20

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК
ОГНОО:2018.04.20

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

М.АЙНУР ОГНОО: 2018.04.20
Х.МАНАРГҮЛ
Д.НАЗГҮЛ
Б.ҮҮРИЙНТУЯА
Ж.НАЗГҮЛ
Х.ЕРКЕБУЛАН